Сэлбэ гол нь Туул голын цутгалуудын нэг бөгөөд ус хурах талбай нь (ус судлалын Дамбадаржаа харуулаар) хойт өргөргийн $47^0$55'- $48^0$15', зүүн уртрагийн 106^0 50'-107^0 00' хооронд байрлана. Голын нийт ус хурах талбай нь ойролцоогоор 300 км^2 гаруй болно. Сэлбэ гол нь Бага Хэнтийн нурууны баруун өмнөд хажуугийн салбар бэсрэг уулс Их Баян уул (2033 м) ба Цохиот уул (1706 м)-аас эх авах ба Их баян ба Багабаян голуудын бэлчээр Сэлбэ нэртэй болж, Туул голд Улаанбаатар хот орчмоор (4-р ДЦС) цутгана. Голын дагуу Хандгайт, Шарга морьт, Яргайт, Бэлх зэрэг жижиг гол горхи, булгууд болон хур бороо элбэгтэй үед хоёр хажуугийн уулсаас хуурай сайруудын урсац Сэлбэ голыг сэлбэнэ.

Сэлбэ голын дагуу Санзай болон Дамбадаржаад усны горим нөөцийн ажиглалт хэмжилтийг хийсэн (1985-2008). Сэлбэ голын савд дунджаар 245-260 мм тунадас унах ба хамгийн их тунадас унадаг 7 ба 8-р сарын тунадас гантай жил 10-20 мм байх бол хур бороо

элбэгтэй жил 80-130 мм-д хүрнэ. Дулааны улирлын хур тунадасны нийбэр 160-340 мм-ийн хооронд хэлбэлзэнэ. Хур тунадасны эрчимшлийн хувьд Сэлбэ голын савд 1 минутанд дундажаар 0.2-1.0 мм, 30 минутад 5-8 мм болон 1 мм/мин буюу 1 цагт 60 мм орчим эрчимшилтэй ширүүн бороо орох тохиолдол бий.

Дулааны улиралд Сэлбэ голын усны горим, үүний дотор усны түвшин, урсацын хэмжээг хур тунадасны хэмжээ, эрчимшил шууд тодорхойлдог онцлогтой. Голын сав газарт 10-20 мм хур тунадас орсон тохиолдолд бүрд голын усны түвшин, урсац нэмэгдэн хэлбэлзэнэ.

2.5. Төсөл хэрэгжиж орчны амьтны аймаг, бүрэлдэхүүн

Судалгаа хийж буй газар нь хүн амын төвлөрөл ихтэй, хотын төвд байрлах тул энд ан, амьтан гэх зүйл байхгүй байна. Харин Нийслэлийн ногоон бүсийн амьтадын талаархи мэдээллийг доор оруулав. Нийслэлийн ногоон бүсийн нутаг дэвсгэр нь амьтны аймгийн газарзүйн мужлалтаараа Умардын их мужийн хөвч тайгын дэд мужийн Хэнтийн тойрогт багтана. Судлаачдын тооцоолсноор Нийслэлийн ногоон бүс нутагт 50 орчим зүйл хөхтөн амьтад тэмдэглэгджээ. Эдгээрээс буга, бор гөрөөс, зэрлэг гахай, хүдэр, янгир зэрэг туурайтан амьтад ногоон бүсийн шилмүүст болон холимог ойд амьдардаг боловч их хотын чимээ шуугиан хүн, авто хөсөг, бэлчээр тэжээлийн хүрэлцээ зэргээс шалтгаалан нэг газар байнга оршин амьдардаггүй улирлын чанартай шилжин нүүдллэдэг онцлогтой.

2.6. Төсөл хэрэгжих орчны нийгэм, эдийн засгийн хөгжил

Баянзүрх дүүрэг: Улаанбаатар хотын зүүн талд байрлах Баянзүрх дүүрэг нь нийслэлийн хамгийн том дүүрэг юм. Богд Хан Уулын Бага тэнгэр, Богино Хүрхрээ, Чулуут, Бумбат, Залаат, Төр хурах ам болон Хар усан тохой зэрэг ан амьтан, цэцэг жимс, ой мод, рашаан ус, эмийн ургамал бүхий үзэсгэлэнт сайхан байгалийг цогцлоон нийт 124.4 мянган га газрыг хамарч оршдог. Монгол Улсын хүн амын 10 хувь, Нийслэл хотын хүн амын 30 гаруй хувь нь амьдардаг нийслэлийн онцгой төвлөрсөн бүс билээ.

Дүүрэг анх 1965 оны 4 дүгээр сард Бүгд Найрамдах Монгол ард Улсын Ардын их хурлын тэргүүлэгчдийн 79 дүгээр зарлигаар Найрамдалын район нэртэй байгуулагдаж, 1992 онд УИХ-ын 18 дугаар тогтоолоор "Баянзүрх" хэмээн нэрлэгджээ.

Хүн ам, нэгжийн зохион байгуулалт. 2020 оны жилийн эцсийн байдлаар 104,800 өрхийн 367,700 хүн амьдарч байна. Засаг захиргааны анхан шатны нэгж болох 28 хороотой. Төрийн үйлчилгээний 37 байгууллага үйлчилгээ явуулж байна. Үндсэн 8 хэлтэстэй. Үүнд: Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Тохижилт, нийгмийн аж ахуйн хэлтэс, хүнс худалдаа, үйлчилгээний хэлтэс, Цэргийн штаб, Хууль, эрх зүйн хэлтэс зэрэг багтана. Мөн харьяа 29 хэлтэстэй. Үүнд: Татварын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн газар, Газар зохион байгуулалтын алба, Хөгжлийн төв, Албан бус-Насан туршийн боловсролын төв, Ахмадын хороо, Биеийн тамир, спортын хороо; Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Дотоод Аудитын алба, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, Мал эмнэлгийн тасаг, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Нийтлэг үйлчилгээний газар-4, Онцгой байдлын хэлтэс, Соёлын ордон, Статистикийн хэлтэс, Улаан заламгайн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Усан спорт сургалтын төв, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн хэлтэс-3, Нийгмийн даатгалын хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба зэрэг орж байна.

Үйл ажиллагаа явуулж буй байгууллага, ААН. Дүүргийн хэмжээнд 2020-2021 оны байдлаар ерөнхий боловсролын 63 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас төрийн өмчийн 36, хувийн хэвшлийн 29 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 189 байгууллага

үйл ажиллагаа явуулж байгаагаас төрийн өмчийн 49 цэцэрлэг, хувийн хэвшлийн 111 цэцэрлэг байна. Түүнчлэн 31,165 байгууллага аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа юм. Харин эрүүл мэндийн томоохон байгууллагууд болох ХӨСҮТ, ХСҮТ, СЭСҮТ, Клиникийн 2 дугаар эмнэлэг, Цэргийн госпиталь, 3 дугаар амаржих газар, Клиник сувилалын 40 дүгээр ясли зэрэг эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд нарийн мэргэжлийн болон суурь, анхан шатны тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй, шуурхай хүргэж байна. Мөн Баянзүрх дүүрэгт Монгол Улсын Шинжлэх ухааны академи, түүний харьяа 6 хүрээлэн, Оросын соёл шинжлэх ухааны төв, Батлан хамгаалах яам байрладаг. Тус дүүрэгт бүх шатны боловсролын байгууллагууд төвлөрсөн.

Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо: Тус хороонд 2021 оны байдлаар 5656 өрхийн 17830 хүн амтай орон сууцны 116 байр, гэр хорооллын 8 өрхтэй, Сэлбэ голын огтолцлоос эхлэн хойшоо Сэлбэ голын гольдрол дагуу Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамжны шинэ гүүрний огтолцол зүүн хойд Намъяанжүгийн гудамжаар төмөр замаар баруун тийш сэлбэ голтой огтолцон цэг хүрсэн хилийн цэстэй байна. Нийт газар нутгийн хэмжээ 40,04 га талбайтай. Хорооны нутаг дэвсгэрт Куба улсын элчин сайдын яам, Доктор авто сүлжээ, Говь Хангай мебель, Намъянжүү соёлын төв, UB tower, Траст трейд компани, Шинэ Монгол сургууль, ОУУБИ сургууль, Улаанбаатар дунд сургууль, Гёте дунд сургууль, Төгсдэлгэрэх дунд сургууль, 111 дүгээр сургууль, 255, 256-р цэцэрлэг, Миний Хайпермаркет, Эко худалдааны төв, Сансар молл сүлжээ дэлгүүр, Натур худалдааны төв, FM107,5, зэрэг 150 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, 44 СӨХ үйл ажиллагаа явуулдаг.

3. ТӨСЛИЙН ЗҮГЭЭС ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Химийн хорт бодис нь агаар, ус, хөрс, хүнсээр дамжин амьсгал, арьс, амаар нэвтрэх замаар хүний генийг хордуулах химийн хорт болон аюултай бодисын хувь нь тухайн бодисын онцлог, шинж чанараас хамаарч өөр өөр байдаг ба хүний биетэй үйлчлэлцэж буй концентраци, хугацаа, агаарын температур, чийглэг болон тухайн хүний нас, эрүүл мэндийн байдлаас хамаардаг. Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд эрсдэл үүсгэж болзошгүй эх үүсвэр нь нэр бүхий 215 төрлийн бодис, бүтээгдэхүүн бөгөөд аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүй нөхцөлд химийн бодисууд нь эрсдэл үүсгэх шууд эх үүсвэр болно. Тус бодисуудын шинж чанар, хоруу чанарын хэжээ, түвшинээс хамааран лабораторийн ажилчид болон сургалт туршилтын хичээлд оролцож буй оюутан сурагчид эрсдэлд өртөгч болно. Ялангуяа химийн бодисуудтай харьцан ажиллах 17 багш, ажилчид илүүтэйгээр өртөж болзошгүй юм.

Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдах, аюулгүй ажиллагааны дүрмийг сайтар баримтлаагүйгээс хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм. Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын явцад хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийг дараах байдлаар гаргав. Үүнд:

1. Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд химийн бодис алдагдах, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх.
2. Химийн бодисыг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бус орчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх.
3. Химийн бодисын сургалт, туршилт явуулж буй лобароториуд болон химийн бодис хадгалах агуулахын үйл ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай, ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх.
4. Химийн бодистой харьцаж ажиллах ажиллагсад нь сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох.
5. Химийн бодисын лаборатори болон агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах.

Хүснэгт 3. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдал, үнэлгээ

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөлөлгүй	Нөлөөллийн эрчим		
			Бага	Дунд	Их
1.	Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд химийн бодис алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.	x			
2.	Химийн бодисыг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бус орчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх.			x	

3.	Химийн бодисын сургалт, туршилт явуулж буй лобароториуд болон химийн бодис хадгалах агуулахын үйл ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай, ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх		x		
4.	Химийн бодистой харьцаж ажиллах ажиллагсад нь сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох.			x	
5.	Химийн бодисыг ашиглах агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах.			x	
Дүгнэлт: Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын үед хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийн нийт үнэлгээгээр 75% нь ”Дунд”, 12,5% нь “бага буюу нөлөөлөлгүй”, 12,5% нь “Бага” нөлөөтэй гэж үзээд төслийн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг “Дунд” гэж үзлээ.					

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 25-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 43 тоот хаягт байрлах “Шинэ Монгол Эрдмийн Хүрээлэн” ХХК-ний “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн батлсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно.

Ерөнхий зүйл. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн (цаашид төсөл хэрэгжүүлэгч гэх) байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газарт хүргүүлэн хянуулж, батлуулна. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)

- ✓ Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө. Тухайн жилийн БОМТ боловсруулах, биелэлтийг тайлагнах журамд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байх бөгөөд хийх ажлын зардлыг тус бүрчлэн тооцож төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан төлөвлөгөө
- ✓ Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө
- ✓ Төслийн талбай орчмын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

- ✓ Үйл ажиллагааны үеийн осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- ✓ Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- ✓ Тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт
- ✓ БОМТ-г нөлөөллийн бүсийн олон нийт, оршин суугчдад тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээний төлөвлөлт зэргээс бүрдэнэ.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4.

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг (1 жилд)	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар					
1.	Агаарт химийн бодис тархах	Химийн бодисын лабораториуд болон химийн бодисын агуулахын дотоод агааржуулалтын системийн ажиллагаанд байнга хяналт тавих	Лабораториуд болон агуулахын дотоод орчин	300.0	MNS 4585:2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. MNS4990:2015 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
2.		Лабораторийн агууржуулалтыг хянах төхөөрөмжтэй болох, гарах агаарыг шүүлтүүрээр дамжуулах, тогтмол ажиллуулах	Лабораториуд	150.0	
Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар					
3.	Ахуйн болон хатуу хог хаягдлаар хөрс бохирдох	Бүх төрлийн хатуу болон ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал түр хадгалах саванд байнга хяналт тавих	Хог хаягдлын цэг, түүний орчинд	50.0	Хог хаягдлын тухай хууль /2017 он/, Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль MNS 5850:2019. “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
4.	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим, сургалт туршилтад ашиглах үед болгоомжгүй байдлаас химийн бодис алдагдсан тохиолдолд хөрс бохирдож болзошгүй	Химийн бодис урвалжийг алдагдахаас сэргийлж байнга анхаарал сэрэмжтэй ажиллах	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, сургалт туршилтын үед	300.0	
Нийт зардал жил жилээр (мян.төг)				**800.0**	

4.2. Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тарих, мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд “Шинэ Монгол Эрдмийн Хүрээлэн” ХХК нь “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-тай хийсэн хамтын ажиллагааны гэрээний дагуу Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 30 шихрэг гацуур суулгаж ургуулахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 5.

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
Газрын тухай хууль болон Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд болон нэгж талбарын орчны тохижилт, цэцэрлэгүүлэлтийн төлөвлөгөөний дагуу НБОГ-аас зохион байгуулах зааж өгсөн талбайд мод тарих үйл ажиллагаанд оролцох	Цаг тухайд нь оролцох, Хавар, Намрын улиралд	Төслийн талбайд	800.0	2026 он	MNS 5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих арчлах
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал			**800.0**	**-**	**-**

4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртсөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлын тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах

“ШМЭХ” ХХК-ний “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төсөл төлөвлөгөөг хийх шаардлагагүй болно.

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Тухайн төслийн үйлчилгээ болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд зайлшгүй нүүлгэх шаардлагатай иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй болно.

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй болно.

4.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6.

Болзошгүй сөрөг нөлөөлөл	**Нөлөөллийг бууруулах арга хэмжээ**	**Арга хэмжээний цар хүрээ**	**Зардал мян.төг**	**Баримтлах эрх зүйн баримт бичиг**
Хог хаягдлын цэг, хог хаягдал ангилан ялгах талбай, төслийн орчинд бохирдол үүсгэж болзошгүй	Хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Улирал бүр	350.0	Хог хаягдлын тухай хууль
	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Тухай бүрт нь		
	Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулж байх	Тогтмол	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр	MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага ЗГ-н 2018 оны 116 тоот Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, бүртгэх тайлагнах журам
	Химийн хог хаягдал, химийн бодисын сав, баглаа боодлыг аюултай хог хаягдал зайлуулах гэрээний дагуу зохицуулах	-		
Нийт зардал /мян.төг/			**350.0**	-

4.7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Авилаа осол эрсдлээс хамгаалах ажил нь аялал жуулчлалын баазын барилга байгууламж барих ажлын үед болон барилгын материал зөөж, тээвэрлэх явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой юм. Доорхи хүснэгтэд төслийн үйл ажиллагааны явцад гарч болзошгүй осол, эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх ажлын хүрээ, давтамж, баримтлах стандарт зэргийг тусган оруулав.

Хүснэгт 7.

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	**Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ**	**Арга хэмжээний цар, хэмжээ**	**Нийт зардал, мян.төг**	**Баримтлах стандарт, аргачлал**
Аянга буух, цахилгаан хэрэгслийн гэмтэл, хэт халалт зэргээс үүдэн гал түймэр гарах	Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах, аюулын гарцын байрлалыг заасан самбар хадах, галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавьсан байх	Лабораториуд, химийн бодис хадгалах агуулах	50.0	Гамшгаас хамгаалах тухай: Зүйл 27-1
Химийн бодис алдагдсанаас ажиллагсадын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Ажиллагсад эрүүл мэндийн үзлэгт орсон байх	Лабораториуд, химийн бодис хадгалах агуулах	171.0	MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
	Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангасан байх			
	Химийн бодистой харьцах үеийн зориулалтын хувцастай байх /гутал, резинэн бээлий, хамгаалалтын хошуувч/			
Химийн бодис болон химийн бодис агуулсан хольц асгарах	Сургалт, туршилт ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах			
Нийт дүн			**221,0**	

4.8. БОМТ-н хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

4.8.1. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүснэгт 8.

№	Хийгдэх ажлын нэр төрөл	Хийгдэх шаардлага	Хийх хугацаа	Ажлын хэмжээ	Шаардагдах хөрөнгө
1.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө Ерөнхий үнэлгээ хийсэн төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/-д хүргүүлж батлуулах	БОАЖС-н 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”	Жил бүрийн 12 дугаар сард багтаан	Жил бүр БОМТ төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Гэрээгээр тохиролцож, мэргэжлийн байгууллагаар
2.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Ерөнхий үнэлгээ хийсэн төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/-д хүргүүлж батлуулах	БОАЖС-н 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”	Тухайн жилийн 11-р сарын 01-ны дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж, дүгнүүлэх	Гэрээгээр тохиролцож, мэргэжлийн байгууллагаар
3.	Хог хаягдлын талаар боловсрол олгох сургалтыг мэргэжлийн байгууллагаар зохион байгуулах	Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгуулагаас сургалт авах	2026 он	-	Дотоод зардлаар
4.	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлж байх	-	Үйл ажиллагааны явцад тогтоосон хугацаанд		Гэрээний дагуу

4.9. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

“ШМЭХ” ХХК-ийн “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, байгаль орчны доройтол, гэнэтийн бохирдлыг хянах, бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор байгаль орчны мониторингийн үйл ажиллагааг явуулна. Мониторинг нь байнгын ажиглалт шинжилгээгээр гарсан үзүүлэлтүүдийн хяналт тэдгээрийн үнэлгээ болон хэтийн төлөв байдлыг урьдчилан таамаглах зэрэг үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааг хяналт, төлөвлөгөөтэй, цэгц явуулахын тулд “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” (ОХШХ)-ийг боловсруулан мөрдөнө.

Орчны бохирдлын байдлын ажиглалт, хяналтыг орчны дээжид хийсэн тоон болон чанарын шинжилгээний үр дүнд үндэслэн явуулна. Шинжилгээгээр гарсан үр дүнг стандартын дагуу батлагдсан ЗДА–тай харьцуулан орчны бохирдлын бие даасан үнэлгээ хийх бөгөөд уг ажлыг хөнгөвчлөхийн тулд тусгай эрх бүхий төрийн байгууллагуудаар батлагдсан ББ-уудын нормативуудыг энэхүү тайланд оруулав.

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаар	SO_2, NO_2, TSP	мг/м^3	*Жилд 1 удаа*	Лабораториуд болон агуулахын дотоод орчин	50,0	200.0	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015
Хөрс	Ялзмаг Урвалын орчин-pH Карбонат Хөдөлгөөнт фосфор, кали (P2O5, K_2O) Цахилгаан дамжуулах чанар	мг	*Жилд 1* удаа	Ил хөрстэй хэсгээс	45.0	144.0	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850-2019 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990
	Механик бүрэлдэхүүн Чулуу						
	Хүнд металлууд Pb,Co,Ni,Cr,Cd						
Нийт						**344.0**	-

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нийт 2515.0 мян.төг зарцуулсан төлөвлөсөн.